

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
Б.НЯМСЭМЖААНЫ 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэдээлэх, тайлагнах, арга зүйн зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлийн үр дүн, үр нөлөөг сайжруулах” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 1.1. Аймгийн хэмжээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хянах, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнг үнэлэх, мэдээлэх, тайлагнах,	-Программ нэвтрүүлэлтийн хувь -Мэдээллийн цахим санг ашиглаж байгаа байгууллагын тоо	0 хувь	100.0 хувь	Нутгийн захиргааны байгууллагуудын хяналт-шинжилгээ үнэлгээний цахим программыг нэвтрүүлэх чиглэлээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн ажиллагааг хариуцан зохион байгуулж, журамд заасан хугацаанд хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна. Аймгийн хэмжээнд хууль тогтоомж, тогтоол шийдвэр, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хянах, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үнэлгээ, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан	04-12 сар	100.0 хувь

	мэдээллийн цахим санг шинээр нэвтрүүлнэ.				Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнг мэдээлэх, тайлагнах мэдээллийн цахим санг шинээр нэвтрүүлж, “Очир ай гүүгэл” ХХК-тай хамтран ажиллаж байна. Цахим мэдээллийн сангийн үйл ажиллагааг хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгийн бүртгэл, хяналт, зохион байгуулалт, тайлагналтын хүрээнд бүх сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын түвшинд хэрэгжүүлж эхлээд байна.		
2.	Арга хэмжээ 1.2. Сумдын Засаг даргын Тамгын газар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ хийж, арга зүйн зөвлөмжөөр хангана.	-Явцын хяналт-шинжилгээ хийгдсэн сумын тоо -Явцын хяналт-шинжилгээ хийсэн байгууллагын тоо	2023 оны байдлаар 5 сум, 3 агентлагийн үйл ажиллагаанд явцын хяналт-шинжилгээ хийгдсэн.	4 сум, 3 агентлагийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж ажилласан байна.	Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад цаг үеийн ажил, тогтоол шийдвэрийн тайлагналт, тайлан мэдээний гаргалт, чанарт анхаарах зэрэг зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж ажилласан.	09-10 сар	30.0 хувь
3.	Арга хэмжээ 1.3. Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын мөрөөр гүйцэтгэл сайжруулах үүрэг чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	-25 агентлаг, 19 сумдад зөвлөмж өгч ажилласан эсэх -Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байдал	23 агентлаг, 19 суманд зөвлөмж хүргүүлж, хяналт тавьж ажилласан.	Зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх ажлыг 10-аас доошгүй байгууллагад хийсэн байна.	Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын мөрөөр аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 25 агентлаг, 19 сумдын Засаг даргын Тамгын газарт зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн.	03-12 сар	100.0 хувь

4.	Арга хэмжээ 1.4. Хоёроос доошгүй сумдын Засаг даргын 2023 оны захирамжид хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлнэ.	-Хамрагдсан сумын тоо -Хяналт-шинжилгээ хийсэн захирамжийн тоо -Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	Сант, баянгол, тарагт, Зүүнбаян-Улаан сумдын Засаг даргын 2022 оны захирамжид хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн.	2 сумын Засаг даргын захирамжид хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж өгч ажилласан байна.	Тарагт, Өлзийт, Баянгол сумын Засаг даргын захирамж боловсруулах хуулийн үндэслэлд зөвлөмж өгч ажиллав. Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс үндэслэлийг тайлбарлаж өгсөн.	06-10 сар	100.0 хувь
5.	Арга хэмжээ 1.5. Нутгийн захиргааны байгууллагуудын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	-ХШҮ-нд хамрагдсан сумын тоо -ХШҮ-нд хамрагдсан байгууллагын тоо -Шалгаруулсан сум, агентлагийн тоо	Журмын дагуу 2022 оны үйл ажиллагааны ХШҮ-ний дүнгээр 5 сум, 3 агентлагийг шалгаруулсан	-	Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумдын ЗДТГ болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг үнэлэн ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд журмын дагуу холбогдох байгууллагуудыг хамруулж, 5 сум (Бат-Өлзий, Хархорин, Есөнзүйл, Өлзийт, Гучин-Ус), 3 агентлагийг (аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улсын бүртгэлийн хэлтэс) шалгаруулав.	01-03 сар	100.0 хувь
6.	Арга хэмжээ 1.6. Улсын төсөвт байгууллагууд (төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд)-ын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ	Хяналт-шинжилгээ хийж ажилласан байгууллагын тоо	-	2-оос доошгүй байгууллагад ажилласан байна.	Улсын төсөвт байгууллагууд (төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд)-ын албан хаагчдад цаг үеийн ажил, тогтоол шийдвэрийн тайлагналт, тайлан мэдээний гаргалт, чанарт анхаарах зэрэг зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж ажилласан.	10-11 сар	30.0 хувь

	хийж, арга зүйн зөвлөмжөөр хангана.						
Зорилт 2. “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 2.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэл, хяналтад авах, мэдээллийн цахим бүртгэл үүсгэх ажлыг зохион байгуулна.	Хяналтад авсан шийдвэрийн хэрэгжилтийн хувь	2023 онд нийт 203 шийдвэрийг бүртгэл хяналтад авч 90.7 хувийн хэрэгжилттэй тайлагнасан.	Хяналтад авах шийдвэрийн тоог нэмэгдүүлж, хэрэгжилтийн дундажыг 90-ээс доошгүй хувьд хүргэж, заасан хугацаанд бүрэн тайлагнаж ажилласан байна.	Энэ оны 12 дугаар сарын байдлаар Монгол улсын Ерөнхий сайдын захирамж 3, Монгол Улсын Засгийн газрын тогтоол 48, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 30 нийт 81 тогтоол шийдвэрийг шинээр бүртгэл хяналтад авч, цахим сан үүсгэн ажилласан. Энэ оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жилийн эцсийн хэрэгжилтийг 2 дугаар сард тайлагнах бөгөөд сар бүрийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 91.0 хувьтай хэрэгжиж байна.	03-12 сар	100.0 хувь
2.	Арга хэмжээ 2.2. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэдээллийн сан үүсгэх, хэрэгжилтийн явцад хагас жил тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр нөлөө, үр дагаврыг үнэлж, мэдээллэн тайлагнана.	-Хяналтад авсан шийдвэрийн тоо -Хагас жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангийн байршуулалт, баталгаажуулалт	2023 онд нийт 203 шийдвэрийг бүртгэл хяналтад авч 90.7 хувийн хэрэгжилттэй тайлагнасан.	Хяналтад авах шийдвэрийн тоог нэмэгдүүлж, хэрэгжилтийн дундажыг 90-ээс доошгүй хувьд хүргэж, заасан хугацаанд бүрэн тайлагнаж ажилласан байна.	Тайлант онд нийт 134 шийдвэрийн 246 заалтын хэрэгжилтийг тайлагнаж байна. Энэ оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жилийн эцсийн хэрэгжилтийг 2 дугаар сард тайлагнах бөгөөд сар бүрийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 91.0 хувьтай хэрэгжиж байна.	06-12 сар	100.0 хувь
3.	Арга хэмжээ 2.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн	Сар бүр цахим санд байршуулж буй	2023 онд нийт 203 шийдвэрийг	80.0 хувь	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оын 1-11 дүгээр сарын хэрэгжилт, хагас жилийн	03-12 сар	100.0 хувь

	хэрэгжилт, үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох байгууллагуудад тайлагнах, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан unelgee.gov.mn -д сар бүр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг байршуулах, программын ашиглалтыг нэмэгдүүлнэ.	шийдвэрийн хэрэгжилтийн хувь	бүртгэл хяналтад авч сар бүр 70-80 хувийн хэрэгжилттэй тайлагнасан байна.		хэрэгжилт, 2024 оны УИХ-ын байнгын хорооны тогтоолын хэрэгжилтэд тус тус хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хугацаанд байршуулсан. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундаж 91.0 хувьтай хэрэгжиж байна. Хэрэгжилтийн тайланг хяналтаас хасуулах саналын хамт программд тэмдэглэл хийн тайлагнаж байна. Мөн аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн Doc.main.mn цахим сайтад бүртгэл хяналтад байгаа хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийг оруулж баяжилт хийсэн.		
4.	Арга хэмжээ 2.4. Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан unelgee.gov.mn -д тухай бүр хэрэгжилтийг байршуулна.	Шуурхай үүрэг даалгаврыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд байршуулсан хэрэгжилтийн хувь	2023 онд нийт 19 шуурхай, үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр 86-91 хувийн хэрэгжилттэй тайлагнасан.	95.0 хувь	Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 81.0 хувьтай хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан unelgee.gov.mn -д тайлагнасан. Мөн Монгол Улсын Ерөнхий сайд орон нутагт ажилласантай холбогдуулан Засгийн газрын 2023 оны 40 дүгээр хуралдааны тэмдэглэлээр аймагт хэрэгжүүлэхээр үүрэг болгосон 14 заалтыг хяналт авч, үүнээс цахим санд аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосон 6 заалтын хэрэгжилтийг сар бүр тайлагнан ажиллаж байна.	03-12 сар	100.0 хувь

					Засгийн газрын хуралдааны 40 дүгээр тэмдэглэлийн хэрэгжилтийн явцыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт цахимаар хүргүүлсэн.		
5.	Арга хэмжээ 2.5. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүртгэл хяналтад авах, тайлагнах чиглэлээр холбогдор албан тушаалтнуудыг чадавхжуулах, сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулна.	Сургалтад оролцсон албан хаагчдын хамрагдалтын хувь	2023 онд нийт 8 удаагийн сургалтаар 170 орчим төрийн албан хаагчийг хамруулсан.	Сургалтад хамрагдсан байгууллагын 10-аас доошгүй хувийг хамруулж, албан хаагчдыг чадавхжуулсан байна.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бодлогын хэлтсүүд, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын 57 албан хаагчидад “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт сургалтыг орсон.	06-12 сар	100.0 хувь
6.	Арга хэмжээ 2.6. Сум агентлагуудын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ хийж, сум агентлагуудыг арга зүйн зөвлөмжөөр хангана.	Сум, агентлагуудад өгсөн зөвлөмжийн тоогоор	2023 онд сум, агентлагуудад хийт 26 зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.	19 сум, 25 агентлагт арга зүйн зөвлөмж хүргүүлсэн байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр авч хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилт зохион байгуулалтыг хангуулах чиглэлээр Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдад цаг үеийн ажил, тогтоол шийдвэрийн тайлагналт, тайлан мэдээний гаргалт, чанарт анхаарах зэрэг зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэж ажилласан.	06-12 сар	100.0 хувь
Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 3.1. Хэлтсийн үйл ажиллагааны тухай мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл,	Мэдээллийн тоо, иргэд, албан байгууллагад хүрсэн байдал	2023 онд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 3 мэдээллийг	6	Аймгийн албан ёсны цахим хуудас Uvurkhangai.mn вэб сайтын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн санд Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжийн 2024 оны төлөвлөгөө,	03-12 сар	100.0 хувь

	аймгийн цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүрд нь мэдээллэх ажлыг зохион байгуулна.		цахим сайтад байршуулсан байна.		Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны жилийн эцсийн тайланг тус тус байршуулсан.		
2.	Арга хэмжээ 3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Ерөнхий сайдын шуурхай үүрэг даалгаврын мэдээллийг хариуцан зохион байгуулна.	Цахим санд байршуулсан мэдээллийн хэрэгжилтийн хувиар	2023 онд нийт 203 шийдвэрийг бүртгэл хяналтад авч сар бүр 70-80 хувийн хэрэгжилттэй тайлагнасан.	80.0 хувь	Тайлант онд нийт 134 шийдвэрийн 246 заалтын хэрэгжилтийг тайлагнаж байна. Энэ оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жилийн эцсийн хэрэгжилтийг 2 дугаар сард тайлагнах бөгөөд сар бүрийн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дундажыг 91.0 хувьтай тайлагнасан байна. Мөн Засгийн газрын 2024 оны 166 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Шинэ хоршоо-чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 81.0 хувьтай хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан unelgee.gov.mn -д тайлагнасан.	03-12 сар	100.0 хувь
3.	Арга хэмжээ 3.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангах, хөтлөн явуулах, байгууллагын архивын баримт бичгийг холбогдох	Архивт хүлээлгэн өгсөн хадгаламжийн тоогоор	2022 онд 6 баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивт шилжүүлсэн.	10	Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн 2023 оны нийт 22 хадгаламжийн нэгжийг архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу архивлан, архивт хүлээн авсан баримтын бүртгэл хөтлөн архивт хүлээлгэн өгсөн.	03 сар	100.0 хувь

	архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу архивт шилжүүлнэ.						
4.	Арга хэмжээ 3.4. Монгол бичгээр баримт бичиг боловсруулах стандартын дагуу 2-оос доошгүй албан бичгийн төслийг монгол бичгээр боловсруулна.	Монгол бичгээр албан бичгийн төсөл боловсруулсан тоогоор	0	Монгол бичгээр 2 албан бичгийн төсөл боловсруулж албажуулсан байна.	Сумдад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг гаргаж ирүүлэх чиглэл өгөхөөр албан бичгийн төслийг боловсруулж байна.	06-12 сар	30.0 хувь

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Удирдлагын академиас зохион байгуулсан Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт, үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл сэдвээр сургагч багш бэлтгэх сургалтад хамрагдах.	Сургалтад хамрагдсан байдал	-	Сургалтад бүрэн хамрагдаж гэрчилгээ авсан байна.	Удирдлагын академиас зохион байгуулсан Монгол улсын хөгжлийн бодлого, хэрэгжилт, үр дүнд суурилсан төлөвлөлт, гүйцэтгэл сэдвээр сургагч багш бэлтгэх цахим болон танхим хосолсон сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан. Тус сургалтаас сурсан хичээлээр бодлогын хэлтсүүдэд мэдээлэл өгч, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин боловсруулахад чиглэл болгож ажиллав.	11 сар	100.0 хувь
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2.	Шалгуур үзүүлэлтийн	-	Шалгуур үзүүлэлтийн	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024	11 сар	100.0 хувь

	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны шалгуур үзүүлэлт, зорилтот түвшингийн хэрэгжилтийг гаргах.	биелэлтийг нэгтгэсэн байдал		биелэлтийг гаргасан байна.	оны шалгуур үзүүлэлт, зорилтот түвшингийн 81 заалтын хэрэгжилтийг холбогдох бодлогын хэлтсүүдээс авч нэгтгэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллав.		
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг гаргах.	Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг боловсруулсан байдал.	-	Шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг боловсруулж, батлуулсан байна.	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг гаргахдаа үйл ажиллагааны хөтөлбөрийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 18 үр дүнд 34 шалгуур үзүүлэлтийг нэгтгэн гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хурлаар хэлэлцэн, баталсан.	11-12 сар	100.0 хувь

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин		
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Монгол бичгийн мэдлэгээ нэмэгдүүлэх чиглэлээр бие даан суралцана.	Монгол бичгийн мэдлэгээ нэмэгдүүлж, бие даан суралцсан эсэх	-	Монгол бичгийн цагаан толгой болон дүрмийн мэдлэгийг нэмэгдүүлж, уншиж, бичих чадвараа сайжруулсан байна.	Монгол бичгийн цагаан толгой болон дүрмийн мэдлэгийг нэмэгдүүлж, уншиж, бичих чадвараа сайжруулах чиглэлээр medle.mn цахим сайтаас монгол хэл, бичгийн цахим хичээлийг бие даан судалсан.	03-12 сар	100.0 хувь

2.	Арга хэмжээ 2. Шинээр мөрдөгдөж байгаа дүрэм, журам, хуулийн шинэчлэлтэй танилцаж, судална.	Хууль, дүрэм журмын шинэчлэлтэй танилцаж, үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажилласан эсэх	-	Өөрийн мэдлэгээ нэмэгдүүлж, олсон мэдлэгээ бусадтай хуваалцах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан байна.	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын өөрчлөлтийг судалсан.	03-12 сар	100.0 хувь
----	---	---	---	--	--	-----------	------------

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ
ШИЙДВЭР ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)

Б.НЯМСЭМЖААН /  /

(Нэр, гарын үсэг)

2024.12.05

(Огноо)